

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
АВТОТЭЭВРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ТАНИЛЦУУЛГА**

2025.02.15

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Автотээврийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Үйл ажиллагаанд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А-87 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ыг тус тус үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

/Хүснэгт1/

№	Зорилт	Нийт	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Үнэлгээ /хувиар/
			100	90	70	50	30	0		
1	1	7	4	-	2	2	-	-	-	80.0
2	2	4	1	-	1	1	1	-	-	62.5
3	3	3	3	-	-	-	-	-	-	100.0
4	4	4	1	-	-	-	3	-	-	47.5
5	5	2	2	-	-	-	-	-	-	100.0
6	6	3	2	1	-	-	-	-	-	96.6
7	7	5	4	-	-	1	-	-	-	90.0
8	8	2	1	-	-	1	-	-	-	75.0
9	9	3	3	-	-	-	-	-	-	100.0
10	10	11	6	-	2	2	1	-	-	79.0
11	11	7	5	-	-	2	-	-	-	91.4
12	12	14	6	-	4	2	2	-	-	74.2
Нийт		66	38	1	11	9	7	-	-	80.6

2.2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн

чиглэлийн хэрэгжилт:

/Хүснэгт 3/

№	Арга хэмжээний дугаар	Арга хэмжээ	Хэрэгжилт хувь
1	8.1.7.	Инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг зам, тээврийн салбарт нэвтрүүлж, ухаалаг тээврийн нэгдсэн тогтолцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	100
2	9.3.4.	Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна.	70
3	9.5.5.	Хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төвийг нээн ажиллуулна.	100

2.3. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд Зам, тээврийн салбар хэрэгжүүлэн ажиллах нийт 46 арга хэмжээ байна. Үүнээс Автотээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

2.4. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт:

/Хүснэгт 4/

№	Шийдвэрийн төрөл	Нийт	Үүнээс /хувиар/					Үнэлгээ /хувь/
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	Монгол Улсын хууль	8	1	7	-	-	-	73.7
2	УИХ-ийн тогтоол	10	4	6	-	-	-	82.0
3	УИХ-ийн БХ-ны тогтоол	1	1	-	-	-	-	100.0
4	ҮАБЗ-ийн зөвлөмж	1	1	-	-	-	-	100.0
5	Засгийн газрын тогтоол	7	2	3	2	-	-	67.1
6	ЕС захирамж	3	3	-	-	-	-	100.0
7	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	21	13	6	1	-	1	87.5
8	Засгийн газрын Албан даалгавар	3	2	-	1	-	-	76.6
Нийт		54	27	22	4	-	1	82.3

2.5. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт:

/Хүснэгт 6/

Нийт	Үүнээс /хувиар/					Үнэлгээ
	100	70	30	0	Хугацаа болоогүй	
19	11	5	3	-	-	81.0

2.6. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

/Хүснэгт 8/

Нийт	Үүнээс /хувиар/					Үнэлгээ
	100	70	30	0	Хүчингүй болсон	
20	14	3	2	-	1	87.9

2.7. Зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

/Хүснэгт 10/

Нийт	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Биелэлт хувь
	100	90	70	50	30	0		
12	7	3	2	-	-	-	-	92.5

2.8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу тус газрын чиг үүрэгт хамаарах мэдээлвэл зохих 2 мэдээ мэдээллийг үнэлэхэд дундаж хэрэгжилт **100.0** хувь байна.

3. Үнэлэлт:

3.1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А-87 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, МУ-ын Хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Үндсэн чиглэл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Нийслэлтэй байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө, Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилт зэрэг 8 үзүүлэлтийн дундаж үнэлгээ **83.3** хувь байна. Доорх хүснэгтээр үнэлгээг нэгтгэж үзүүлээ.

/Хүснэгт 11/

Д/д		Нийт	Үүнээс /хувиар/	Хугацаа	Хүчингүй	Үнэлгээ
-----	--	------	-----------------	---------	----------	---------

	Арга хэмжээний нэр		100	90	70	50	30	0	болоогүй	болсон	/хувиар/
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	66	38	1	11	9	7		-	-	80.6
2	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	2	2	-	-	-	-	-	-	-	100,0
3	МУ-ын 5 жилийн Үндсэн чиглэл	3	2	-	1	-	-	-	-	-	90,0
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	54	27	-	22	-	4	-	1	-	82.3
5	Сайдын тушаал	19	11	-	5	-	3	-	-	-	81.0
6	ТНБД-ын тушаал	20	14	-	3	-	2	-	-	1	87.9
7	Санамж бичиг	12	7	3	2	-	-	-	-	-	92.5
8	Нийтийн мэдээллийн ил тод байдал	2	2	-	-	-	-	-	-	-	100,0
Нийт		178	103	4	44	9	16	-	1	1	83.3

3.2. Автотээврийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд 8 үзүүлэлтийн 178 арга хэмжээг хэрэгжүүлэн бүрэн хэрэгжсэн 103, 90 хувийн 4, 70 хувийн 44, 50 хувийн 9, 30 хувийн 16, хугацаа болоогүй 1, хүчингүй болсон 1 арга хэмжээний дундаж хэрэгжилт **83.3** хувь байна.

4. Санал, зөвлөмж:

4.1. Автотээврийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зарим арга хэмжээний зорилтод түвшинг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулаагүй, хугацааг улирал бүрээр задалж төлөвлөөгүй байна. Жишээ нь:

Арга хэмжээ 10.5: Үндэсний Тээврийн хорооны үйл ажиллагааг хангаж ажиллах арга хэмжээний зорилтод түвшинг төлөвлөхдөө “*холбогдох ажлууд хийгдсэн*” гэж тодорхойгүй байдлаар төлөвлөсөн;

Арга хэмжээ 12.6: “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” -гийн нэгдсэн платформ байгуулах арга хэмжээг I, II улиралд “*төслийн хэрэгжилтийн явц*” гэж төлөвлөсөн нь биелэлтийг тайлагнахдаа хэрэгжилтийг хувиар тайлагнаагүй тул үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна;

Арга хэмжээ 12.7: Олон улсын, улсын чанартай авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтын системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх арга хэмжээний зорилтод түвшинг “*хагас, бүтэн жилээр 50 хувьд*” хүргэх гэж зорилтод түвшинг ижил байдлаар төлөвлөсөн байна.

4.2. Автотээврийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажлын албаны төлөвлөгөөг батлуулах, батлагдсан төлөвлөгөөний дагуу зорилтод түвшин, хэрэгжүүлэх хугацаанд арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад онцгойлон анхаарах;

4.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажлын албаны 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр ХШҮДАГ-т ирүүлэн дүгнүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах;

4.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр тайлагнаж байгаатай холбогдуулан хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, нэгжийн төлөвлөгөөнд тусгах, эзэнжүүлэн жил бүр хүрэх түвшинг тодорхойлон төлөвлөгөө батлуулах;

4.5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд анхаарч, мэдээ, мэдээллийг тухай бүр яамны сайтад болон мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, сурталчлан таниулах чиглэлээр ажиллах;

4.6. Төрийн жинхэнэ албан хаагч бүр өөрийн хариуцсан ажлын биелэлтийг заасан хугацаанд, товч бөгөөд тоо баримттай, тогтмол үнэн зөвөөр тайлагнаж ажиллахыг тус тус зөвлөж байна.

СХШҮДАГ